

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Үйлдвэрийн газарт нэвтрүүлж буй олон улсын стандартын баталгаажуулалт хийх ажил”

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202312453

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь “Үйлдвэрийн газарт нэвтрүүлж буй олон улсын стандартын баталгаажуулалт хийх ажил” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-т нэвтрүүлж байгаа олон улсын ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо стандартуудын хэрэгжилтийг үнэлж баталгаажуулалт хийх зөвлөх үйлчилгээ болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох (ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадварын талаар мэдээлэл гэх мэт) мэдээллийг ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно

- Байгууллагын танилцуулга
- Олон улсын ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо стандартуудыг хэрэгжилтийг үнэлэн аудит хийж баталгаажуулалт хийх хүчин төгөлдөр итгэмжлэлтэй байх
- Татварын тодорхойлолт, шүүхийн тусгай архивын лавлагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна
- Нэгдмэл менежментийн тогтолцооны олон улсын стандартын баталгаажуулалт хийсэн туршлагатайг нотлох баримт ирүүлэх бөгөөд тухай чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан байна.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2023 оны 05 сарын 22-ны өдрийн 10:00 цаг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ www.tender.gov.mn цахим хаягаар 2023 оны 05 сарын 23-ны өдрийн 10:00 цаг–ийн дотор ирүүлнэ үү.

“Монголросцветмет” ТӨҮГ
www.tender.gov.mn

